

**УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ ( Ж-4.5, Х-3)**

**2010 он**

№	Үзүүлэлт		Үр дүнгийн үнэлгээ	
			Хувь	Оноо
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	93.7	4.68
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	61.8	3.09
		3.Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	90.4	4.52
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1.Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	97.3	4.86
		2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	85.9	4.29
		3.Монгол улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	100	5
		4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	69.6	3.48
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1.Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн Ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	91	4.55
		2.Төсвийн Ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	95	4.75
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	100	5
		2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	100	5
		3.Төсөв, санхүүгийн ил тод байдал	100	5
		4.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	100	5
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	88.2	4.41
		2.Хэрэглэгчийн үнэлгээ	92.2	4.61
<b>Ерөнхий үнэлгээ</b>			<b>91.0</b>	<b>4.55</b>

**Увс аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газрын  
2010 оны үйл ажиллагаа, хяналт шинжилгээний тайлан**

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу тус аймгийг Засаг дарга, Засаг даргын тамгын газрын 2010 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт шинжилгээ хийж, үр дүнг танилцуулж байна.

Эдийн засгийн хувьсамтгай байдал, санхүүгийн хүндрэлийг хамтын хүчээр даван туулж хувийн хэвшил, иргэд, айл өрх, хамт олон бүхний хүчин чармайлтын үр дүнд нийгэм, соёлын зориулалттай 20 барилга, 57 жижиг үйлдвэр ашиглалтад орж, газар тариалангийн үйлдвэрлэл 43.3 хувиар өсөж, орлогод эзлэх зарлагын хувь 56.5 хувьд хүрч, зам, барилга худалдаа, үйлчилгээний

салбарын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт 8.8 хувиар нэмэгдэж, жилийн зөрчил, малын хулгай 23 хувиар буурсан зэрэг аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нааштай үр дүн гарлаа.

Мөн Увсын ард түмэн төмөр барс жилийн онцлог үйл явдлаар:

1. Монгол төрийн нэрт зүтгэлтэн Ю.Цэдэнбалын хөшөө, цогцолбор, Галдан Бошгот хааны хүндэтгэлийн өргөөг барьж бүтээн босголоо.

2. 2010 он хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын жил болж, 21.1 тэрбум төгрөгний барилга угсралт, их засварын ажил хийгдлээ.

3. Увс аймгийн эдийн засаг хөгжлийн форум, соёлын өдрүүдийг Улаанбаатар хотод зохион байгуулж, музейн 500 гаруй нэгжүзмэр, ховордсон ном, зохиолын үзэсгэлэн гаргаж аймгаа сурталчиллаа.

4. Увс аймаг ойрын 20 жилд авч байгаагүй өндөр ургац хураан авлаа.

5. Улаангом хотын доторхи хар зам, гэрэлтүүлэг, орон сууцнууд, байгууллага, гэр хорооллын гадаад өнгө төрхийг шинэчилсэн.

6. Худалдан авах үйл ажиллагаанд анх удаа иргэний нийгмийн байгууллагуудаар мониторинг хийлгэсэн.

7. Тус аймагт үндэсний бөхийн өсвөрийн “Улсын а варга” шалгаруулах тэмцээн анх удаа боллоо.

8. Чацаргана хөтөлбөр”-ийн 2-р үе шат хэрэгжиж, “Увс хүний хөгжлийн хөтөч загвар” хөтөлбөр батлагдлаа.

9. “Нэг цонх”-ны үйлчилгээг нээж төрийн үйлчилгээ шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөл бүрдлээ.

10. Орон гэргүй 273 өрхийг гэржүүлсэн явдлуудыг нэрлэж, хийжүүбэсэнээ үнэлж дүгнэсэн байна.

Мөн онд аймгийн Засаг даргын тамгын газар нь улсын “Төрийн архив”-ын үзлэгт 94.2 хувьтай шалгагдаж, Засгийн газрын хяналт шинжилгээгээр “хангалттай сайн” үнэлгээ авсан нь хамт олны хичээл зүтгэл, үйл ажиллагааны үр дүн юм.

**1.1. Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт:** Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор эдгээр баримт бичигт суурилсан аймгийн 2021 он хүртэлх “Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр” -ийг аймгийн ИТХ-ын 2008.09.30-ны өдрийн 8/02 дугаар тогтоолоор баталж, хэрэгжилтийг хангах ажил аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөв төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байна.

МХЗ-уудыг орон нутагт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх богино хугацааны төслийг НҮБХАС-гийн дэмжлэгтэйгээр тус аймагт хэрэгжүүлж, аймгийн МХЗ-уудын тулгамдаж буй асуудал, хэрэгжилтийн талаар анхны тайланг бичиж, аймгийн өнөөгийн нөхцөл байдлыг бодитойгоор үнэлж, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, улмаар орон нутгийн удирдлагын цаашдын үйл ажиллагаа, бодлого зорилтын чиглэл, арга зам, хүрэх түвшинг тодорхойлсон.

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийн 54 зорилтоос 100% хэрэгжсэн 26 заалт, 90% хэрэгжсэн 25 заалт, 70% хэрэгжсэн 3 заалт, дундач биелэлт **93.7** хувьтай байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт №1 буюу Uvs2010Re2.doc -оос үзнэ үү.

**1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан Увс аймагтай холбогдох зорилтуудын биелэлт:** Монгол улсын засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Увс аймагтай холбогдох 96 зорилт, 170 заалт тусгагдсан бөгөөд дээрх зорилт, заалтуудыг хэлтэс агентлаг, аймгийн ЗДТГ-ын ажилтнуудад хариуцуулан өгч биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцон гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, заалтуудыг салбараар ангилан авч үзвэл эрүүл мэнд, биеийн тамир спортын чиглэлээр 10 зорилт, 19 заалт, боловсрол, соёл, хүүхдийн чиглэлээр 16 зорилт, 29 заалт, хөдөлмөр, халамж үйлчилгээ, нийгмийн хамгааллын чиглэлээр 12 зорилт, 13 заалт, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр 7 зорилт, 10 заалт, дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр 7 зорилт, 12 заалт, хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр 15 зорилт, 33 заалт, байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцааны чиглэлээр 15 зорилт, 31 заалт, хууль эрх зүй, мэргэжлийн хяналтын чиглэлээр 5 зорилт, 7 заалт, төрийн захиргааны чиглэлээр 9 зорилт, 17 заалт тус тус хэрэгжиж байна.

Аймгийн хэмжээнд 2010 оны эхнээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд хэрэгжилтийн явц 2010 оны жилийн эцсийн байдлаар 61,8 хувьтай байгаа нь 2009 оны жилийн эцсээс 29,6 хувиар өссөн байна.

Гэхдээ 2009-2010 оны өвөл, хаврын зудын улмаас мал их хэмжээгээр хорогдож, олон малчин өрх амьжиргааныхаа эх үүсвэрээс салсан нь ядуурал, ажилгүйдлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хангахад сөргөөр нөлөөлж байна.

2010 оны жилийн эцсийн байдлаар ерөнхий боловсролын сургуулийг 3-р ээлжгүй болгох, газрын төлбөрийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал хүргүүлэх, аймгийн төвийн дулаан хангамжийн байдалд судалгаа хийж шинэчлэлийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрх зүйн туслалцааны төвийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн туслалцаатайгаар байгуулж, үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, төсвийн байгууллагуудын ерөнхий менежерүүдийг манлайлах ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт хамруулан сургаж, чадавхийг бэхжүүлэх, төрийн албан тушаалын чиг үүргийн шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр хүлээх үүрэг хариуцлагыг нь тодорхой тусгасан ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулан баталж мөрдүүлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг шинэчлэн боловсруулж батлан мөрдүүлэх, дайчилгааны 1, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтын чанар, оролцох бүрэлдхүүнийг үе шаттайгаар нэмэгдүүлэх зэрэг зорилтууд зуун хувийн биелэлттэй байна.

Мөн хүн амын бичиг үсэгт тайлагдалтын түвшинг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулиас завсардсан сурагчдад албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачлагад тулгуурлан орон нутаг, бүсийн хөгжил, салбарын бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэж буй төв болон орон нутгийн байгууллагуудын ажил үүргийн зохион байгуулалтыг сайжруулж, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүнд сурталгүй, ил тод, шуурхай болгох арга хэмжээ авах, “Ногоон хувьсгал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ойжуулах, мод бут, сөөг, загийг үрээр тарималжуулах, ногоон байгууламжийг эрчимжүүлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгжийн төсөл, арга хэмжээг санхүүгийн болон бусад хэлбэрээр дэмжих, согтууруулах ундааны үйлдвэрлэл үйлчилгээний цэгүүдийн үйл

ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг шалгалт тогтмол явуулж гаргасан санал дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээ авах, хил бүс нутгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх таатай нөхцлийг хангах талаар холбогдох талуудтай ажиллах зэрэг зорилтуудын биелэлт 90 хувьтай биелэгдэж байна.

Харин “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” батлагдаагүй байгаатай холбогдуулан уг хөтөлбөртэй холбоотой 2 заалт болон хот суурин газрын цэвэрлэх байгууламжид техник технологийн шинэчлэл хийж ашиглалтыг сайжруулан, стандартын шаардлага хангуулах, тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны төлөв байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гарган тухайн газар нутгийн онцлог, нөөц даацад тохируулан аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх, аялал жуулчлалын томоохон цогцолбор төв барьж байгуулах гэсэн зорилтууд 10хувь буюу хангалтгүй биелэлттэй байна.

Үүнээс гадна “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийг зарлаагүй байгаа тул энэ зорилт огт биелээгүй байна.

Засгийн газрын газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Увс аймагтай холбогдох 96 зорилт, 170 заалтын биелэлтийг 2010 оны жил эцсийн байдлаар авч үзвэл 15 заалт 100 хувь, 26 заалт 90 хувь, 49 заалт 70 хувь, 48 заалт 50 хувь, 26 заалт 30 хувь, 5 заалт 10 хувь, 1 заалт 0 хувийн биелэлттэй, дундач хувь **61,8** байна.

Дэлгэрэнгүй тайланг ХАВСРАЛТ № 2 буюу Uvs2010Re3.doc -оос үзнэ үү.

**1.3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт:** Аймгийн хэмжээнд УИХ, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 94 үндэсний хөтөлбөрийг хяналтанд авч тайлан мэдээг гаргахдаа Засгийн газрын 2009 оны 285 дугаар тогтоолыг, хяналт шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Мөн аймгийг хөгжүүлэх 2008-2021 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, зорилт, үр дүнгийн гэрээ болон хөгжлийн баримт бичгүүдэд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Томоохон хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүд боловсруулан аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн болон Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлаж, хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумдын ажил дүгнэх үзүүлэлтэнд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг нэг үзүүлэлт болгон үнэлж дүгнэж байна.

Зарим байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар санаачлага гарган төсөл хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлж байгаа нь тухайн хөтөлбөрийн санхүүжилтийг бага боловч шийдэж, хэрэгжилтийг эрчимжүүлэхэд ач холбогдолтой болсон байна.

Тайлант онд аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг Засаг даргын дэргэдэх 20 агентаг зохион байгуулан энэ ажлын хүрээнд үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөө, өгөөжийг ард иргэд, нийгэм рүү чиглүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрт хяналт шинжилгээ хийж, хөтөлбөр хариуцсан ажилтан нарт мэргэжил аргагүйн зөвлөмж өгч ажиллаа.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа 94 үндэсний хөтөлбөрөөс боловсрол соёлын салбарт 16, Эрүүл мэнд, спортын салбарт 13, х үүхэд, нийгмийн хамгааллын салбарт 6, байгаль орчны салбарт 15, Хөдөө аж ахуйн салбарт 14, Урьдчилсан үйлдвэр, уул уурхай, барилгын салбарт 19, төрийн захиргаа хууль эрхзүйн чиглэлээр 11 хөтөлбөр нь бусад салбарт хэрэгжиж байна.

Өнгөрсөн оноос 9 хөтөлбөрийг шинээр хяналтанд авч үндэсний 94 хөтөлбөр 100 хувийн хэрэгжилттэй 41, 90 хувийн хэрэгжилттэй 41, 70 хувийн хэрэгжилттэй 10, 10 хувийн хэрэгжилттэй 1, 0 хувийн хэрэгжилттэй 1 хөтөлбөр, дундач хэрэгжилт **90.4** хувьтай байна.

Үндэсний хөтөлбөрүүдийн дэлгэрэнгүй тайлан мэдээг холбогдох Яамдуудад тайлант оны эцэст хүргүүлээ.

Дэлгэрэнгүй тайланг Uvs2010Re4.doc -оос үзнэ үү.

**2.1. Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн Увс аймагтай холбоотой зорилтын биелэлт:** Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тус аймагтай холбоотой нэр зааж дэвшүүлсэн 11 зорилтын хэрэгжилт **97.3** хувьтай байна.

Дэлгэрэнгүй тайланг Uvs2010Re5.doc -оос үзнэ үү.

**2.2 . Хууль тогтоомж, засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт:** УИХ, Засгийн газрын тогтоол, тэмдэглэлийг тухай бүр нь хяналтанд авч аймгийн удирдлагууд болон хэлтсийн дарга нарт танилцуулж, хэрэгжилтийг нь хангуулж ажиллах талаар албан тушаалтанд хариуцуулан өгч, биелэлтийг улирал бүр тооцож, мэдээ тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж ажиллаа.

2010 онд нийт 156 шийдвэрийн 252 заалтыг хяналтанд авч биелэлтийг гаргахад 100% хэрэгжсэн 83, 90% хэрэгжсэн заалт 99, 70% хэрэгжсэн заалт 36, 50% хэрэгжсэн заалт 12, 30% хэрэгжсэн заалт 15, 10% хэрэгжсэн заалт 7 , тогтоол шийдвэрийн дундач биелэлт **85,9** хувьтай байна.

2010 онд 20 агентлаг, 19 сумаас Засгийн газрын 96 тогтоолын 115 заалт, 7 хуралдааны тэмдэглэлийн 18 заалт, 1 албан даалгаврын 7 заалтын биелэлтийг гаргуулж хэрэгжилтийг тооцож ажиллалаа.

Нийт агентлаг, сумдад Засгийн газрын “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” 1999 оны 55 дугаар тогтоол , “Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр батлах тухай” 1999 оны 96 дугаар тогтоол, “Нийгмийн халамжийн хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 1999 оны 36 дугаар тогтоол, “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 2002 оны 129 дугаар тогтоол, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”- ийг батлах тухай 2003 оны 160 дугаар тогтоол, “Ногоон хувьсгал -2” үндэсний хөтөлбөр батлах тухай 2004 оны 169 дугаар, “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр батлах тухай” 2005 оны 64 дугаар, “Нэг суурин - Нэг бүтээгдэхүүн хөтөлбөр батлах тухай” 2005 оны 138 дугаар, “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах сэргээн засварлах хөтөлбөр батлах тухай” 2007 оны 303 дугаар тогтоол, “Нээлтэй хаалганы өдөр зохион байгуулах” 2007 оны 190 дугаар тогтоол “Хүнсний аюулгүй байдлыг хангах, архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2008 оны 04 дугаар тогтоол, “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” 2008 оны 07 дугаар тогтоолууд амжилттай хэрэгжиж үйл ажиллагаа нь тогтворжсон байна.

“Цаг агаарын аюултай үзэгдлийн тухай сэрэмжлүүлэг мэдээг малчид ард иргэдэд шуурхай хүргэж гамшгаас урьдчилан сэргийлэх тухай” 2009 оны 41 дүгээр, “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай” 2009 оны 56 дугаар, “2009 оны төсөвтөө багтаан үйл ажиллагаагаа явуулж, шинэ жилийн баяр ёслолын үйл ажиллагаанд хавтгайруулан зардал гаргахгүй байх тухай” 2009 оны 68 дугаар, “Сахилга дэг журам, хариуцлагыг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” 2009 оны 03 дугаар албан даалгавар зэрэг Засгийн газрын хуралдаанаар өгсөн цаг үеийн шинж чанартай үүрэг даалгаврууд шуурхай хэрэгжсэн байна.

Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын хүрээнд аймгийн засаг даргын дэргэдэх 20 агентлаг, 19 сумын ажлыг үнэлж дүгнэх журмаа шинэчлэж аймгийн Засаг даргын 2010 оны 257 дугаар захирамж гаргалаа. Тус тогтоолоор засгийн газрын тогтоол, үндэсний хөтөлбөр, бодлого зорилтын хэрэгжилт, биелэлтийг үнэлж дүгнэх ажлыг аймгийн хэмжээнд нэг мөр болгон мөрдөж байна. Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг удирдамжийн дагуу 2 сум 20 агентлагт аймгийн засаг даргын нэрэмжит үзлэгийг зохион байгуулан дүнг засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ.

“Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” 2009 оны 143 дугаар тогтоол, “Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах тухай” 2007 оны 190 дугаар тогтоол, “Өргөдөл гомдол шийдвэрлэх тухай” 2005 оны 67 дугаар тогтоолын биелэлтийг хэрэгжүүлж ажиллах тал дээр Боловсрол соёлын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын алба, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгал, Татварын хэлтсүүд гарын авлага түгээх, үйлчилгээ авахад шаардлагатай бүрдүүлэх материалын талаар зөвлөгөө мэдээлэл өгч тодорхой ажил зохион байгуулан сайн ажилласан байна

“Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2010 оны зорилтонд 6 багийн төвийг шинээр барьж, 4 багийн төвийг засварлан тохижуулж, 25 багийн засаг даргыг унаажуулж, жишиг багийн болзол журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгууллаа.

2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгох тухай тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2010 оны 132 дугаар захирамжаар “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган батлаж, хэрэгжилтийн тайланг гарган Үндэсний хөгжил шинэтгэлийн хороонд хүргүүллээ.

Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн дэлгэрэнгүй тайланг тоотоор болон электрон шуудангаар ЗГХЭГ-т тус тус хүргүүлсэн болно.

Дэлгэрэнгүй тайланг ХАВСРАЛТ -3 , Uvs2010Re6.doc -оос үзнэ үү.

**2.3. Монгол улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт** 100 хувь бөгөөд дэлгэрэнгүй тайланг Uvs2010Re7.doc -оос үзнэ үү.

**2.4. Увс аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:** Монгол улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны болон тус аймгийг 2008-2021 онд хөгжүүлэх стратегийн хөгжлийн хөтөлбөрийн үзэл санаа, Мянганы хөгжлийн зорилтод үндэслэн 130 багц зорилт бүхий аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан түүнийг хэрэгжүүлэх 329 заалт бүхий төлөвлөгөө гаргаж, зорилт, заалт бүрийг холбогдох хэлтэс, тасгийн ажилтнуудад нэрчлэн хариуцуулж жил, жилийн эдийн засгийн зорилтонд тусган биелэлтийг нь хагас, бүтэн жилээр тооцон ажиллаж байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд 7,12 сард хяналт шинжилгээ хийж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжилт нь удааширч байгаа заалтуудыг хэрэгжүүлэх талаар санаачлага гарган ажиллах талаар холбогдох хэлтэс, тасаг, агентлагын дарга нарт тэмдэглэлээр мэдэгдэл хүргүүлж биелэлтийг нь тооцон ажиллав.

Мөн сум, агентлаг, ЗДТГ-ын ажилтнуудын ажил дүгнэх нэг үзүүлт болгож, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусган биелэлтийг нь холбогдох ажилтнуудаар хамгаалуулан ажиллаж байгаа нь зохих үр дүнд хүрч байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг Увсын амьдрал сонины захиалгат дугаараар 4000 ш –ийг гаргаж айл өрхүүдэд сумын ЗДТГ-аар дамжуулан хүргэлээ.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт , бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтыг харуулсан танилцуулга, зурагт хуудсыг гаргаж иргэдэд хүргэхээр бэлэн болоод байна.

2010 оныг “**Эрчимжсэн газар тариалан – Бүтээн байгуулалт**” –ын жил болгон зарлаж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийг 2010 онд хөгжүүлэх **74** багц зорилт дэвш үүлэн **45** зорилт **100** хувь, **20** зорилт **90** хувь, **3** зорилт **70** хувь, **3** зорилт **50** хувь, **2** зорилт **30** хувь хэрэгжиж төлөвлөгөөний биелэлт **90.8** хувьтай байна.

2010 оны зорилтуудыг улсын төсөв, хүний хөгжил сангийн хөрөнгө, орон нутгийн төсөв, аймгийн авто замын сан, төсөл, хөтөлбөр, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 22.4 тэрбум төгрөг гаргаж хэрэгжүүллээ.

Өнгөрсөн оныг ерөнхийд нь дүгнэж үзвэл төсөв санхүүгийн зохих боломж бүрдсэн, аймаг сумын өмнө тулгамдаж байсан гол гол асуудлууд , Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тодорхой хэсгийг шийдвэрлэсэн, төрөлх Улаангом хотын өнгө төрх зам, гэрэл сайжирсан, төрийн бүх шатны байгууллагын ажил үйлчилгээнд болон бизнесийн салбарт ахиц дэвшил гарсан жил болж өнгөрлөө.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 130 багц зорилтын **14** зорилт 100 хувь, **31** зорилт 90 хувь, **46** зорилт 70 хувь, **28** зорилт 50 хувь, **7** зорилт 30 хувь, **4** зорилт 10 хувьтай хэрэгжиж дундач хэрэгжилт **69,6** хувьтай байна.

Аймгийн 2010 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн ИТХ-ын хуралдаанаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, 2010 оны нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг авч хэлэлцээд **69.9** хэрэгжилттэй байгааг баталгаажууллаа.

Дэлгэрэнгүй тайланг Uvs2010Re8.doc -оос үзнэ үү.

**3.1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн Ерөнхийлөн захирагчтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний биелэлт:** Аймгийн Засаг дарга Яамны сайд нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг, ажилтнууд, агентлагуудын дарга, сумын Засаг дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусган биелэлтийг нь хагас, бүтэн жилээр тооцож ажиллаа.

Тайлант оны хагас жилээр бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг, хяналт шинжилгээг хийж хэрэгжилт удааширалтай зорилт заалтыг эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар асуудал оруулан холбогдох шийдвэрийг гаргуулан ажиллаа.

Мөн салбарын сайдуудтай байгуулсан гэрээнд гүйцэтгэлийн хяналт шинжилгээ хийж, тайланг холбогдох газруудад тус тус хүргүүллээ.

Яамны сайд нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг оновчтой зохион байгуулж ажилласны дүнд БСШУЯ-ны 5 ангийн 12 бүтээгдэхүүнийг 100 хувиар, ЭМЯ-ны 6 ангийн 15 бүтээгдэхүүнийг 89.5 хувиар, БХЯ-ны 4 ангийн 17 бүтээгдэхүүнийг 98.5 хувиар, Тэргүүн шадар Сайдын 5 ангийн 5 бүтээгдэхүүнийг 100 хувиар, Шадар сайдын 12 ангийн 384 бүтээгдэхүүнийг 97.6хувиар, НХХЯ-ны 5 ангийн 41 бүтээгдэхүүнийг 97.4хувиар, ХЗДХЯ-ны 5 ангийн 31 бүтээгдэхүүнийг 98.7 хувиар, БОАЖЯ-ны 4 ангийн 4 бүтээгдэхүүнийг 100 хувиар, Үндэсний статистикийн хорооны 4 ангийн 17 бүтээгдэхүүнийг 89.9 хувиар,ХХААХҮЯ-ны 5 ангийн 16 бүтээгдэхүүнийг 100 хувиар тус тус биелүүллээ.

Дэлхийн эдийн засгийн хямрал, төсвийн хүрэлцээгүй байдал тухайн онд нийлүүлэх бүтээгдэхүүний биелэлтэнд нөлөөлсөн хэдий ч орон нутгийн төсвийн хөрөнгийн нөөц боломжийг бүрэн дүүрэн ашигласны дүнд Яам, тусгай газрын нийт 55 ангийн 542 бүтээгдэхүүнийг дундчаар **91** хувиар биелүүлсэн нь гэрээнд заасан үүргээ 6 хувиар давуулан биелүүлсэн байна.

**3.2. Төсвийн Ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт :** 2010 онд Тамгын газрын хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан **640,852,5** мянган төгрөгийн өртөг бүхий **6 ангийн 100 бүтээгдэхүүнийг** төсвийн Ерөнхийлөн захирагчид нийлүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж төсвийн Ерөнхийлөн захирагчаас гэрээнд заасан үүргээ **95.0** хувиар биелүүлсэн үнэлгээ авлаа.

Дэлгэрэнгүй тайланг Uvs2010Re10.doc -оос үзнэ үү.

**4.1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал-/ Монгол улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол/-ын хэрэгжилт 100 хувьтай байна.**

Дэлгэрэнгүй тайланг Uvs2010Re11.doc -оос үзнэ үү.

**5.1. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт:** Эдийн засаг , нийгмийн 52 үзүүлэлтээс 10 үзүүлэлт өмнөх оноос буурсан , бусад 42 үзүүлэлт ахисан буюу өмнөх оны түвшинд байна. Буурсан үзүүлэлтээс малын тоо, эхийн эндэгдлийн үзүүлэлт огцом буурсан байна.

**5.2. Хэрэглэгчийн үнэлгээ:** Монгол улсын Засгийн газрын болон аймаг, орон нутгаас хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэрүүд ард иргэдийн амьдрал ахуйд хэрхэн үр өгөөжөө өгч байгаа цаашид засч сайжруулах ямар ажил, асуудлууд байгааг тодотгох, төрийн чиг үүрэг гүйцэтгэж байгаа төрийн байгууллагуудаас үйлчилгээг ард иргэдэд хэрхэн хүргэж байгаа талаар үнэлгээг 27 асуулгаар сүүлийн 5 жил тогтмол авч аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан сум, агентлагын ажил дүгнэх үзүүлэлтэнд оруулж дүгнэж хэвшлээ.

Энэ удаагийн судалгаанд 19 сумын 2200 иргэнийг хамруулан үнэлгээ авч шинжилгээ хийхэд төрийн хууль тогтоомж, бодлогыг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй, чанартай хүргэх, төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй ажил хэрэгч байдлыг хангуулахад анхаарлаа чиглүүлэн ажилласаны үр дүн гэж үзэж байна. Мөн 2010 онд Увс аймагт хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын томоохон ажиллууд хийгдэж аймаг орны өнгө үзэмж сайжирч, ажилгүйдэл ядуурал, хүн амын шилжилт хөдөлгөөн буурсан нь төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар хүртээмжийг харуулж байна.

Мөн 3-аас дааш оноо авсан тохиолдолд хангалттай, 2.9-ээс доош үнэлгээ авсан бол хангалтгүй гэж үзсэн бөгөөд энэ үнэлгээний дагуу дараах 27 үзүүлэлт бүгд хангалттай байна. Энэ нь өнгөрсөн оноос 1.04-1.71-ээр ахиж, ерөнхий дүнгээр 1.5-аар ахисан байна.

### АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР